

## **ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛД АМЖИЛТ ГАРГАСАН ОЮУТАНД МУИС-ИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ**

### **Нэг. Ерөнхий зүйл**

МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлэгийг дараах шаардлагыг хангасан оюутанд олгоно. Үүнд:

- 1.1. Сүүлийн 4 улирлын голч дүн 3.0 доошгүй;
- 2.1. Тодорхой сэдвийн хүрээнд улсын төсөлт болон гэрээт эрдэм шинжилгээний ажил, судалгааны экспедицид оролцдог байх;
- 2.2. Зохион бүтээсэн багаж төхөөрөмж, эрдэм шинжилгээний илтгэл нь уралдаанд шалгарсан байх (хийсэн бүтээлийн үр дүн нь хэвлэн нийтлэгдсэн буюу үйлдвэрлэл, практикт шилжсэн, ШБОС-ын гэрчилгээ, лиценз авсан бол онцгойлон үзэх үндэслэл болно);
- 2.3. Эрдэм шинжилгээний ажилд дур сонирхолтой, авьяас чадвартай оюутан болохыг мэргэжлийн эрдэмтэд, оюутны хамт олон батлан тодорхойлсон;

### **Хоёр. Нэрэмжит тэтгэлэг олгох**

- 2.1. Нэрэмжит тэтгэлэг олгох оюутны нэрийг тэнхмийн хурлаас дэвшүүлж Оюутны зөвлөлийн саналыг авна.
- 2.2. Бүрэлдэхүүн сургууль бүр тухайн хичээлийн жилд тус бүр нэг оюутан тодорхойлох бөгөөд Эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн протокол үйлдсэн байна.
- 2.3. Бүрэлдэхүүн сургуулиудаас ирсэн материалыг Оюутанд үйлчлэх төв нэгтгэн Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, захирлын тушаалаар тэтгэлэг, гэрчилгээг олгоно.
- 2.4. Нэрэмжит тэтгэлэгт нэр дэвшиж буй оюутнуудын материал нь нэгдсэн загвараар бөглөсөн товч анкет, бүрэлдэхүүн сургуулийн захирлын тодорхойлолт, Эрдмийн зөвлөлийн протоколоос бүрдэнэ. Тодорхойлолтонд тэтгэлэгт нэр дэвшигдсэн гол үзүүлэлт болох эрдэм шинжилгээний ажлын тухай үнэлэлт дүгнэлттэйгээр тодорхой бичнэ.
- 2.5. Эрдэм шинжилгээний ажилд тогтвортой, онцгой амжилт гаргасан оюутанд үргэлжлүүлэн олгож болох бөгөөд уг асуудлыг тэтгэлэг шинээр олгохтой адилаар шийдвэрлэнэ.
- 2.6. Нэрэмжит тэтгэлэгийг хичээлийн жилд нэг удаа олгох ба тэтгэлэг нь тухайн жилийн сургалтын төлбөрийн 40%-тай тэнцэх хэмжээтэй байхаар бодож эрдэм шинжилгээний зардлаас гаргана.

**Ц.ДАМДИНСҮРЭН, Ш.ЛУВСАНВАНДАН, Б.РЕНЧИН НАРЫН  
НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГТ СУРГАЛТЫН ЖУРАМ**

**Нэг. Ерөнхий үндэслэл**

- 1.1. МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 1992 оны 2-р сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу нэрт монгол судлаач Ц.Дамдинсүрэн, Ш.Лувсанвандан, Б.Ренчин нарын нэрэмжит тэтгэлэг олгоно.
- 1.2. Тэтгэлэгийн зорилго нь монгол судлалын тодорхой чиглэлээр ажилладаг гадаадын залуу судлаачдыг ахисан түвшний сургалтад хамруулж, мэргэшихэд нь дэмжлэг үзүүлэхэд оршино. Үүнд:
  - 1.2.1. Ц.Дамдинсүрэнгийн нэрэмжит тэтгэлэг - Монголын утга зохиол, түүх;
  - 1.2.2. Ш.Лувсанванданы нэрэмжит тэтгэлэг - Монгол хэл бичиг, эх бичиг, алтай судлал;
  - 1.2.3. Б.Ренчиний нэрэмжит тэтгэлэг - утга соёл, угсаатны зүй, хүн судлал.
- 1.3. Нэрэмжит тэтгэлэгийг жилд тус бүр нэг хүнд олгох бөгөөд сургалтыг тухайн чиглэлийн дагуу бүрэлдэхүүн сургууль хариуцан зохион байгуулна.

**Хоёр. Нэрэмжит тэтгэлэгт хамруулах болзол**

- 2.1. Монгол судлалын чиглэлээр докторантурт суралцаж байгаа болон докторын дараах судалгааны ажил хийх сонирхолтой 40 хүртэл настай судлаачийг сонгон шалгаруулна.
- 2.2. Суралцагч нь жил бүрийн 1-р сарын 15 эсвэл 9-р сарын 01-нээс 3-6 сарын хугацаагаар ирж, тодорхой хөтөлбөрийн дагуу сургалтанд хамрагдах буюу судалгааны ажил хийнэ.
- 2.3. Нэрэмжит тэтгэлэг авахыг хүсэгч нь доорхи материалыг бүрдүүлж, сургалтад хамрагдахаас 3 сарын өмнө МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнд ирүүлнэ. Үүнд:
  - 2.3.1. Боловсрол, ажлын туршлагыг илтгэх биеийн байцаалт (CV);
  - 2.3.2. Бүтээлийн жагсаалт;
  - 2.3.3. Суралцах зорилго, судлах зүйлийн хамрах хүрээ;
  - 2.3.4. Онцлох хүсэлт: Аль тэнхимд хэний удирдланд сурах, нийслэлээс өөр газар явах шаардлагатай эсэх;
  - 2.3.5. Эрүүл мэндийн үзлэгийн бичиг.

**Гурав. Сургалтын дэг**

- 3.1. Тэтгэлэгт шалгарсан судлаачид мэргэжлийн эрдэмтнийг зөвлөх профессороор томилж ажиллуулна.
- 3.2. Нэрэмжит тэтгэлэгээр суралцагчид дараах хангамж эдлүүлнэ. Үүнд:
  - 3.2.1. Оюутны байранд суулгах;
  - 3.2.2. Боловсролын зэргээс хамааруулж сар бүр МУИС-ийн багшийн сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгох
  - 3.2.3. Архивын материал, ном хэвлэл худалдаж авах, бичлэг хийх зэргээр судалгааны материал цуглуулахад нь зориулж нэг удаа 400,000 төгрөг өгөх.
  - 3.2.4. Орон нутагт богино хугацаагаар судалгааны материал цуглуулах ажлаар явахад нэг удаа 400,000 төгрөгийн дэмжлэг үзүүлэх.
- 3.3. Суралцагч суралцах хугацаандаа судалгааны семинарт идэвхтэй оролцож илтгэл тавих, судалгааны ажлын үр дүнгээр эрдэм шинжилгээний өгүүлэл бичих үүрэг хүлээнэ.
- 3.4. Тэтгэлэгээр суралцагч сургалт дуусах болох үед зөвлөхийн удирдлагаар судалгааны ажлын тайланг гаргаж, тэнхимд шаардлагатай гэж үзвэл бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлд тайлагнана.
- 3.5. Суралцагч сургалтын хугацаанд МУИС-ийн дүрэм, бусад холбогдох журам, зааврыг мөрдөнө.

## ГАДААДЫН ИРГЭНД МУИС-ИЙН НЭРЭМЖИТ МОНГОЛ ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

### 1. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар МУИС-д монгол хэлний сургалтанд хамрагдах хүсэлтэй гадаад иргэдийг тэтгэлэгт хамруулах, сонгон шалгаруулахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2. Тэтгэлгийн зорилго нь монгол хэл сурах хүсэлтэй гадаад оюутнуудыг дэмжих, ингэснээр монгол судлалыг МУИС-д төвлөрүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд сургуулийн нэр хүндийг олон улсын тавцанд өсгөх юм.
- 1.3. Энэхүү тэтгэлгийг жил бүр уламжлал болгон зарлах бөгөөд тухайн хичээлийн жилд гадаадын 1-2 оюутанд МУИС-ийн монгол хэлний бэлтгэлд суралцах бүтэн жилийн тэтгэлгийг олгоно. Тэтгэлэгтэй холбоотой асуудлыг Монгол судлалын хүрээлэн, Оюутанд үйлчлэх төв хамтран зохион байгуулна.
- 1.4. Тэтгэлгийн талаархи мэдээллийг монгол, англи хэлээр МУИС-ийн цахим хуудсанд байрлуулахаас гадна гэрээтэй болон хамтран ажилладаг сургуулиудад шууд хүргэнэ.

### 2. Ерөнхий зүйл

- 2.1. МУИС-ийн нэрэмжит монгол хэлний сургалтын бүтэн жилийн тэтгэлэгт хамрагдахаар сонгогдсон гадаадын иргэн /цаашид “тэтгэлэг авагч” гэх/ сургалтын төлбөр 2600 ам.доллар болон гадаад оюутны дотуур байрны төлбөр 400 ам.долларын төлбөрөөс чөлөөлөгдөнө. Мөн амжиргааны тэтгэлэг болгон сар бүр 300,000₮ олгоно.
- 2.2. Тэтгэлэг хүлээн авагч нь МУИС-ийн монгол хэлний бэлтгэл ангид бусад орны оюутнуудын хамт нэг жилийн сургалтын хөтөлбөрт хамрагдаж, 20 кредитийн хичээлд сууж, төгсөлтийн гэрчилгээ авна. Тэтгэлэгт сургалтанд хамрагдах хугацаа жилийн бүрийн 9 дүгээр сарын 1-нээс 6 дугаар сарын 10-ны хооронд байна.
- 2.3. Тэтгэлэгт хөтөлбөрт нэрээ дэвшүүлэхэд бүртгэлийн хураамж 150 ам.доллар байна.
- 2.4. Тэтгэлэг хүлээн авагч нь гадаад оюутны байранд амьдрахгүй тохиолдолд байрны зардлыг өөрөө хариуцна.
- 2.5. Тэтгэлэг хүлээн авагч нь эрүүл мэндийн даатгалд өөрөө даатгуулахаас гадна ирж буцах онгоцны тийзийг мөн өөрөө хариуцна.

### 3. Тэтгэлэг хүсэгчид тавих шалгуур

- 3.1. Монгол хэлний анхан шатны мэдлэгтэй байх.
- 3.2. Тэтгэлэгт хамрагдахыг хүсэгч нь гадаадын аль нэг их сургуулийн ази, дорно дахин, монгол судлалын бакалаврын түвшний 1-3 дугаар курсийн оюутан байх.
- 3.3. Тэтгэлэгт хөтөлбөрт гадаад оронд суугаа оюутан залуучууд мэдүүлэх бөгөөд Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэдийг хамруулахгүй.
- 3.4. Монгол Улсад ямар нэгэн тэтгэлэгээр сурч байгаагүй оюутан байна.

### 4. Бүртгэл

- 4.1. Бүртгэлийг тухайн жилийн 4 дугаар сарын 1-нээс 5 дугаар сарын 31-ний хооронд явуулах бөгөөд 6 дугаар сарын 1-нд шалгаруулалтын эцсийн дүн гарна.
- 4.2. Бүрдүүлэх материал:
  - Монгол хэлний хичээлийн дүн
  - Монгол буюу англи хэлээр бичсэн эссэ (700 үгтэй байх)
  - Хураамж 150 ам.доллар (МУИС-ийн дансаар шилжүүлэх)
  - Гадаад паспортын хуулбар
  - Цээж зураг - 2 хувь (3x4)
  - Багшийн тодорхойлолт, 2 хүнээс

- Эрүүл мэндийн шинжилгээний бичиг
- МУИС-ийн тэтгэлэгийн анкет

## 5. Тэтгэлэгийн төсөв, санхүүжилт

### 5.1. Бэлэн мөнгөний зардал

	Зарцуулалт	Мөнгөний дүн /₮/	Хаана тушаах
1	Урилгын хураамж	21 400	ГИХАЭГ
2	Оршин суух зөвшөөрлийн хураамж	2 000	БСШУЯ
3	Сар бүрийн тэтгэлэг	300000*10 сар	Тэтгэлэг авагчид
4	Оршин суух зөвшөөрлийн хураамж	60 000	ГИХАЭГ
5	Оршин суух зөвшөөрлийн сунгалтын хураамж	2 000	БСШУЯ
6	Оршин суух зөвшөөрлийн сунгалтын хураамж	50 000	ГИХАЭГ
7	Хээрийн болон танилцах дадлагын зардал	150 000	
7	Нийт	3 285 400	

### Бэлэн бус мөнгөний зардал

	Зарцуулалт	Мөнгөний дүн \$	Тайлбар
1	Сургалтын төлбөр	2 600	Жилд нэг удаа
2	Оюутны байрны төлбөр	40*10 сар	Сар бүр
3	Нийт	2 000	

5.2. Тэтгэлэг хүлээн авагчийн зардлын санхүүжилтыг тэтгэлэгт хөтөлбөрт санал ирүүлсэн оролцогчдын бүртгэлийн хураамжаас /150\$/ бүрдүүлэх бөгөөд хураамжийн үлдэгдэл мөнгийг сургуулийн дансанд байршуулна.

5.3. Тухайн жилийн тэтгэлэгт хамрагдах өргөдөл гаргасан хүмүүсийн төлсөн бүртгэлийн хураамж тэтгэлэг авагчдын зардалд хүрэхгүй тохиолдолд МУИС-иас нөхөж санхүүжилт хийнэ.

## 6. Сонгон шалгаруулалт

6.1. Сонгон шалгаруулалтын дүнг 6 дугаар сарын 1-нд гаргаж сургуулийн цахим хуудсанд зарлах бөгөөд шалгарсан тэтгэлэг хүлээн авагчид тусгайлан мэдэгдэнэ.

6.2. Шалгаруулах комисс 4-5 гишүүнтэй байх бөгөөд энэ нь Монгол судлалын хүрээлэн, Монгол хэл соёлын сургууль, Гадаад хэл соёлын сургууль, Оюутанд үйлчлэх төвийн төлөөллөөс бүрдэнэ.

6.3. Комиссын ажил, үүргийн хуваарилалт

Гүйцэтгэгч	Хийх ажил	Хугацаа
Комиссын ахлагч	-Комиссын гишүүдийг томилуулах -Товч намтартай танилцаж оноо тавина	III сар ҮП/1-ҮП/21
Оюутанд үйлчлэх төвийн мэргэжилтэн	-Тэтгэлгийн зар явуулах -Бичиг баримтыг шуудангаар хүлээн авах -Дипломын дүнгийн голч оноог тооцож, зохих дүнг тавина	IY/01-IY/31 Y/1-ҮП/1 ҮП/1-ҮП/21
ГХСС- аас томилогдсон багш	-Эссэ бүрийг уншиж оноо өгнө -Багш нарын тодорхойлолттой танилцаж, үнэлгээ өгч оноо гаргана	ҮП/1-ҮП/21
Комиссын гишүүд	Нэгдсэн шалгаруулалт	ҮП/25-ҮП/30

6.4 Комиссын гишүүдийн ажилласан хугацааг тооцож, тухайн үед мөрдөж буй тарифаар цагийн хөлс олгоно.

## 7. Бусад

7.1. Тэтгэлэг авагч МУИС-д ирэхэд онгоцны буудлаас тосох, оюутны байранд суулгах болон суралцаж байх үеийн орох гарах виз, оршин суух зөвшөөрөл авахтай холбоотой бусад үйлчилгээг Оюутанд үйлчлэх төвийн мэргэжилтэн хариуцна.

7.2. Тэтгэлэг авагч Монгол Улсын хууль, МУИС-ийн дотоод журам зөрчсөн болон тэтгэлэгт хамрагдах хүсэлтээ худал мэдүүлсэн тохиолдолд тэтгэлгийг зогсоох бөгөөд нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.